

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШУУРХАЙ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2019.10.07

№26

Дархан

Аймгийн Засаг даргын шуурхай хурал 2019 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 08.00 цагт аймгийн ЗДТГ-ын хурлын танхимд эхлэв. Хурлыг аймгийн Засаг дарга С.Насанбат удирдаж нийт 25 гишүүнээс 16 оролцож хурлын ирц 64 хувьтай байв.

Хэлэлцсэн нь:

Сумд, хэлтэс, агентлагуудын 7 хоногийн тайлан

Өгөгдсөн үүрэг даалгавар:

МСҮТ дулаан аваагүй байна гэсэн. Дулааныг нь олгуулах /Э.Равжаадэлгэрэх/

Оюуны ирээдүй цогцолборт шугам хагарсан гэсэн мэдээлэл байна. Үүнийг яаралтай шийдвэрлэх /Э.Равжаадэлгэрэх/

60 айлын орон сууцтай холбоотой багийн дарга нартай холбогдон мэдээлэл хийх /Л.Алтанчимэг/

Залуус хөгжлийн төв дулаан аваагүй байна /Э.Равжаадэлгэрэх, НҮА/

17-ны өдрийг угтан хийх ажлуудыг нэрэмжит болгон зохион байгуулах /бүгд/

Тэд Дархан үйл ажиллагаанд байгууллагууд өөрсдөө болон залуучуудаа оролцуулах /бүгд/

15-16-ны өдрүүд ахлах түшмэлийн ангилалд сургалт зохион байгуулна. /бүгд/

Хөрөнгө оруулалтын хаалтын ажлыг зохион байгуулах /ХОХБТХ/

ЗДҮАХ-т хэрэгжилт удаашралттай заалтуудын хөрөнгө оруулалтын дүнг Б.Жаргалсайханд өгсөн. Төсөв санхүү тусаагүй байх вий дээ. Хэрэгжилтийг хангуулах тал дээр анхаарч ажиллая. Бодлогын хэлтсүүд агентлагуудтайгаа хамтарч ажиллах шаардлагатай байна. /ЗА, ТЗУХ, ХЭЗХ, НБХ, ХОХБТХ, ХШҮДАХ, СТСХ/

9 сарын 27-ны шуурхай хурлаас өгсөн үүргийн биелэлт орж ирсэн. Дархан сумын ЗДТГ дээр хэрэгжилт дутуу байна шүү.

2020 оны асуудал руу орох шаардлагатай байна. ХОХБТХ иргэдтэй хийх уулзалтаа зохион байгуулж саналыг нь бичгээр авах шаардалагаай. ТЗУХ, Дархан сумын ЗДТГ хамтраад мэдээ тайлангаа танилцуулах замаар иргэдийн саналыг авмаар байна. /Бүгд/

ЗА, Ерөнхий архитектор, ХОХБТХ нийлээд ирсэн санал дээр анализ хийгээд 2020 онд юу хийхээ боловсруулалт хийх шаардлагатай. Жишээлбэл 16 давхарын урд гэрлэн дохио хийнэ гэж хэлээд 2 жил болсон. Анагаахын уулзварыг өргөсөгөнтэй холбогдуулан гэрлэн дохионы шаардалага байгаа. /ЗА, Ерөнхий архитектор, ХОХБТХ/

Захирагчийн алба гэхэд 2020 онд хэдэн байр будах юм. Ингээд төлөвлөлтөө гаргаад боловсруулад төлөөлөгчдийн зөвлөгөөнд танилцуул /ЗА/

Театрын урд талын уулзвар битүү байна. Нэмэлт уулзварууд хийе. ХОХБТХ дээр зураг төсвийг нь эртнээс хийлгэе. /Ерөнхий архитектор, ХОХБТХ/

10 сарын 17-ныг угтсан иргэдийн уулзалт, 11, 12 дугар сарын гишүүдийн уулзалт дээр төлөвлөлтөө танилцуулах. Шат шатны төлөөлөгчидэд нь төлөвлөлтөө танилцуулъя. /ЗА, Ерөнхий архитектор, ХОХБТХ/

Гэрэлтүүлгийг гэр хороололд нэмэгдүүлэх хэрэгтэй. Энэ 7 хоногоос эхлүүлэх шаардлагатай. Дархан сум ЗА, ХОХБТХ, Сумдын дарга нарт үүрэг болгож байна.

Иргэдийн уулзалтыг залуучууд театрт зохион байгуулъя. Иргэдээс урьдчилсан байдлаар санал авах /МТА/ Утсаар урьдчилж санал авая. УИХ гишүүдийг оруулах юм уу? Төлөвлөлтөө хийе. Болж бүтэхгүй байгаа юмаа олж харъя. Ажлын төлөвлөгөөнд оруулах /МТА, ТЗУХ/

Бүлгээр дамжуулаад баг үүрүүдээр нь төлөөлөгчдийн тайланг тавиулах ажлыг зохион байгуулж болно. Видео нэвтрүүлгүүд бэлтгэж цувралаар гаргах ажлыг цар хүрээг нь өргөтгөх. Баг хороогоор нь гаргах. Жишээлбэл 13 дугаар баг дээр юу хийсэн гэдгээр нэг видео хийх. Түүнийгээ хэвлэлд тавих. Хагас, бүтэн сайнд орой үдэш суугаарай. Техникүүд нь сайжирсан. ИТХ-ын төлөөлөгчдийг ярилцлагад оруулах. Хэсэгчилсэн буюу тойргоор нь видеог хийх /МТА/

Агентлагуудын дарга нар хийж хэрэгжүүлж байгаа ажлаа өгөх авах / бүгд/

ХО-ын ажлын гүйцэтгэл дээр анхаарах , Мягмар гарагийн өглөөний хурлыг чанаржуулах авах /ХОХБТХ/

12 дугаар сарын 25-ны өдөр гэхэд Тендерийн хэмнэлтийн мөнгөө өгнө.

Хэдэн бичиг явуулсан бэ? Асуудал шийдвэрлүүлэх зорилгоор хэдэн бичиг гарсан бэ? /ТЗУХ/

5 дугаар багийн нутаг дэвсгэр дээр явагдаж байгаа Бурхант хясаатын ажил чанарын өндөр түвшинд хийгдэж байгаа юм байна. Хамгийн сайн явж байгаа ажил. Баг, хорооны дарга нар нь ч гэсэн үүнийгээ мэддэггүй юм байна. авах /МТА/

Хотын баярыг өндөр хэмжээнд зохион байгуулах. Братск хотын дарга арай амжихгүй байх. Эрээн хотын дарга ирэх төлөвлөгөөтэй байгаа. /ТЗУХ/

Иргэдийн гоожинг олгуулах. Хөрш зэргэлдээ сумдаас авч өгөх. Уурхайн борлуулалт хэвийн явагдаж байгаа.

БО-ны сангаас тодорхой мөнгө үлдсэн. Энэ хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах. АЖ салбарт оруулах. ТББ нь мятрашгүй явж байна. Бодитой ажил хийж байгаа нь ТББ. Байгаль орчны ажлуудыг ТББ, ИНБ-уудаар хийлгэх нь зөв юм байна. Үр дүн гаргаж чадаж байна.

БО-ны сангийн жагсаалтыг гаргаж надад танилцуулаарай.

ХОХБТХ, Дархан сум, ЕА нийлээд орон сууц барих өргөдлүүдийг хүлээн авч нэгтгэх. Бодлогоо барьж явахгүй бол Улаанбаатарын араас орно шүү. Дэд бүтэцтэй газраа төсөв цуглуулах нэрээр дуудлага худалдаанд өгсөөр байгаад хот төлөвлөлтөө алдах вий.

Үндсэн чиглэл 65 заалттай боловсруулагджээ. Зорилт, зорилгуудаа эргэж хараарай. Биелэлт гарна шүү.

Баавгайн талаар мэдээлэл ирэхгүй байна. Өчигдөр мэдээ авахад унтуулах сум хүлээж байгаа гэсэн мэдээлэл авсан. 2 цаг тутамд мэдээ авая гэсэн ирэхгүй байна /Орхон сум, ОБГ/

БО, ЦГ, ОБГ-аас мэдээ ирэхгүй байна. Жишээлбэл: Төмөрлөгийн үйлдвэрт 43 настай иргэн амиа алдсан. Өчигдөр Жасперт томоохон асуудал үүссэн. Буудлын өрөөнд амь насаа алдсан. Эзэн холбогдогчтой мэдээ мэдээллүүдийг аваад байхгүй бол мэдээлэлгүй байна.

Байшингаа буулгаж дуусгасан уу?

Хонгор сумдын удирдлагууд, ГХБХБГ ажилдаа ирэхгүй байна, Удаа дараа хэлж байгаа. Өнөөдөр өглөө мсж ирж амьд гэдгийг мэдлээ. Төвсийн орлогын мэдээлэл тасраад байна.

ХО-ын хурал дээр Азаа дарга ирж суугаад мэдээлэл аваарай. 6 дугаар багийн нутаг дэвсгэрт чулуу ихтэй шинэ зургаар явахаар болж байгаа.

5,6,7 дугаар багт Баттөмөр гишүүний хийж байгаа дэд бүтцийн ажил асар ач холбогдолтой. Орчин үеийн тохилог, орон сууцны хорооллуудын суурь тавигдах нь байна шүү. МТА сууж ажиллаарай. /МТА/

Хурал 9 цагт 45 минутад дуусав.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС